

ХҮНСНИЙ БУУДАЙН АГУУЛАХАД ТАВИГДАХ ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

(Хүнсний буудай хадгалах агуулах)

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 1.1. Агуулахын эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 1.1.1. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
 - 1.1.2. Бүрэн ажиллагаатай 10-аас доошгүй силостой элеватортай, хашаа, ажлын байртай байх;
 - 1.1.3. Хугацаа хэтэрсэн (татвар, банкны болон бусад) өргүй байх;
 - 1.1.4. Үйлдвэрийн үндсэн ажилчдын тоо 10-аас доошгүй байх;
 - 1.1.5. Хүнсний буудайн чиглэлээр 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж мэргэшсэн барааны мэргэжилтэнтэй байх;
 - 1.1.6. Буудайг иж бүрэн тодорхойлох лаборатори, мэргэжлийн ажиллах хүчинтэй байх;
- 1.2. Агуулах нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 1.2.1. Силос болон тариаг талбайн аргаар хадгалах дээвэрт агуулах, тариа буулгах талбай (задгай агуулах) нь Монгол улсын MNS ISO 6322-2:2008 стандартыг хангасан, 24 цагийн харуул хамгаалалттай, камержуулсан байх;
 - 1.2.2. Агуулахын хашаа нь буудайг саадгүй ачих, буулгах боломжтой, тээврийн хэрэгслийг байрлуулах хангалттай зогсоол, талбайтай;
 - 1.2.3. Агуулах, ажлын байранд ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу тогтмол хийлгэдэг байх;
 - 1.2.4. Элеватор нь Биржийн хүлээн зөвшөөрсөн дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Үүнд:
 - Стандартчилал хэмжилзүйн газрын баталгаа бүхий гэрчилгээтэй, 40-өөс доошгүй тоннын даацтай пүү;
 - Буудайг тээврийн хэрэгслээс буулгаж, хүлээн авах төхөөрөмж;
 - Буудайнд 1 ба 2-р зэргийн цэвэрлэгээ хийх зориулалттай агаарын урсгалаар болон шигшүүрт ажиллагаа хосолсон цэвэрлэх төхөөрөмж;
 - Буудайг хатаах төхөөрөмж;
 - Буудайг зэргээр нь ялгаж, силосуудад хуваарилж ачих дамжуулга;
 - Хадгалалтын үед буудайг технологийн дагуу сэлгэх байгууламж;
 - Буудайг тээврийн хэрэгсэлд ачих төхөөрөмж.
 - 1.2.5. Биржийн агуулахын бүртгэлийн програмыг ажиллуулах компьютер болон принтер, 512kb-аас доошгүй хурдтай интернэт зэрэг дагалдах тоног төхөөрөмжтэй байх;
 - 1.2.6. Барааны бүртгэл хөтлөх ажилтантай байна.

ХОЁР. БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

- 2.1. Итгэмжлэл хүсэгч нь дараах бичиг баримтыг Биржид бүрдүүлж өгнө. Үүнд:
 - 2.1.1. Итгэмжлэл хүссэн өргөдөл;
 - 2.1.2. Агуулахын албан ёсны болон байршил тодорхойлох хаяг, байнга харилцах утас, и-мэйл хаяг;
 - 2.1.3. Силос, ил болон дээвэрт агуулах тус бүрийн чанар, багтаамжийн мэдээлэл;
 - 2.1.4. Агуулахын тоног төхөөрөмжийн талаарх бүрэн мэдээлэл;
 - 2.1.5. Лабораторийн хүчин чадал;
 - 2.1.6. Тариа буулгах тавцан, агуулах, силос тус бүрийн чанар байдлыг илтгэх дэлгэрэнгүй зургууд (8x12-оос доошгүй хэмжээтэй, булан, хана, шал, тааз, хаалга, тоног төхөөрөмжийг дэлгэрэнгүй харуулсан);
 - 2.1.7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хуулбар;
 - 2.1.8. Агуулах, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түүний хуулбар;
 - 2.1.9. Татварын байгууллагын тодорхойлолт, түүний хуулбар;
 - 2.1.10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, түүний хуулбар;
 - 2.1.11. Энэ шалгуур үзүүлэлтийн 1.1.4-т заасан ажилчдын нийгмийн даатгалын дэвтэр, түүний хуулбар;
 - 2.1.12. Агуулах, лабораторийн тоног төхөөрөмжийн гэрчилгээ, түүний хуулбар.
- 2.2. Бүрдүүлэх бичиг баримтын 2.1.1-2.1.6 заалт дахь баримтыг албан бичгээр үйлдэж, тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.
- 2.3. Бүрдүүлэх бичиг баримтын 2.1.7-2.1.12 заалт дахь баримтыг эх хувиар нь авчрах боломжгүй бол тухайн онд нотариатаар баталгаажсан хуулбарыг авчирч болно.

ГУРАВ. ИТГЭМЖЛЭЛ СУНГАХАД ШААРДАГДАХ БИЧИГ БАРИМТ

- 3.1. Итгэмжлэлийн гэрээний хугацаа дуусахаас ажлын 10 өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах гэрээ сунгуулах хүсэлтийг Биржид гаргана.
- 3.2. Итгэмжлэл сунгуулахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 3.2.1. Итгэмжлэл сунгуулах өргөдөл, албан бичгээр;
 - 3.2.2. Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.2-2.1.6 заалтад бүрдүүлсэн бичиг баримтуудаас өөрчлөгдсөн бичиг баримт;
 - 3.2.3. Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1.7-2.1.12 заалт дахь бичиг баримтуудаас (хугацаа дууссан болон бусад шалтгаанаар) шинэчлэгдсэн бичиг баримт.
- 3.3. Итгэмжлэл сунгахад шаардагдах бичиг баримтыг хүлээн авахдаа энэ шалгуур үзүүлэлтийн 2.2 болон 2.3-т заасан нөхцлийг баримтална.

--oOo--